



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/47/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-22
3. Аудитын тайлан.....	22-25
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	26-27
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	27

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийг дэмжих сан
ОНТС	Орон нутгийн төсвөөс санхүүжих



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

дэд.од.14 № 78
танай _____ ны № _____ т

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дашинчилэн сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ковидын урамшуулал, тэтгэмжийн зардалд 17920950 төгрөгийг давхардуулан, батлагдсан орон тоог 1 орон тоогоор илүү 5040000 төгрөгийг тус тус олгосон, бараа ажил үйлчилгээний зардлаас 226000 төгрөгийг шагналын зардалд, хөтөч ажилтаны 420000 төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулын зардлаас тус тус шилжүүлсэн, 894180 төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн, 1252111 төгрөгийн шатахуун зарцуулалт нь даргын цохолт бөглөгдөөгүй, хаашаа хэн явсан нь тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, өмнөх алдаа зөрчил дахин давтагдсан зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1.1-д "хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн;" 37 дугаар 1.13-д "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах," НББ-ийн тухай хуулийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13 дугаар зүйлийн 6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтууд, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын

006020073

29-ны өдрийн 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "зардлын эдийн засгийн ангилах, ашиглах заавар, ЭМС-ын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаал шийдвэрүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийт зөрчлийн 25753241 төгрөгийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын дүнгээс илүү илэрхийлэгдэж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,750,823.84</u>	<u>27,811,840.20</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,707,464.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,707,464.00
3121	Төгрөг	-	2,707,464.00
31211	Төрийн сангийн харилцах	-	2,667,164.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	40,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	35,750,823.84	25,104,376.20
351	Түүхий эд материал	11,993,163.84	9,691,596.20
35110	Тусгай зориулалттай материал	4,598,340.00	-
35130	Эм боох материал	7,394,823.84	9,691,596.20
354	Хангамжийн материал	20,369,660.00	12,086,780.00
35410	Бичиг хэргийн материал	1,147,400.00	-
35420	Аж ахуйн материал	18,485,460.00	10,861,100.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,225,680.00
35460	Хүнсний материал	736,800.00	-
35600	Мал амьтад	3,388,000.00	3,326,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>306,107,279.08</u>	<u>300,577,462.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	306,107,279.08	300,577,462.76
392	Биет хөрөнгө	297,071,779.20	290,448,212.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	720,977,440.00	720,977,440.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(529,898,148.79)	(541,342,235.11)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,651,000.00	80,651,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,054,500.16)	(35,583,833.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,191,402.84	75,990,104.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,976,257.73)	(25,964,709.14)

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,598,865.00	23,118,172.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,418,021.96)	(7,397,726.86)
393	Биет бус хөрөнгө	9,035,499.88	10,129,250.00
39301	Програм хангамж	350,000.00	1,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(262,500.12)	(518,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,948,000.00	8,948,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>341,858,102.92</u>	<u>328,389,302.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>3,028,533.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,028,533.00
413	Өглөг	-	3,028,533.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,028,533.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>341,858,102.92</u>	<u>325,360,769.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	341,858,102.92	325,360,769.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	196,302,799.05	196,302,799.05
51101	Өмч: - төрийн	196,302,799.05	196,302,799.05
512	Хуримтлагдсан үр дүн	(177,371,192.45)	(193,868,525.41)
51210	Өмнөх үеийн үр дүн	(177,371,192.45)	(177,371,192.45)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(16,497,332.96)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	322,926,496.32	322,926,496.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>341,858,102.92</u>	<u>328,389,302.96</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	496,747,015.82	960,843,942.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	451,983,315.82	675,143,650.43
120	Нийтлэг татварын бус орлого	91,192,575.82	280,714,260.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	91,192,575.82	24,006,000.00

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	276,000.00	315,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	90,916,575.82	23,691,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		14,745,949.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		241,962,310.87
122	Тусламжийн орлого	24,941,940.00	5,369,190.00
122001	Хандив тусламж /дотоод/	24,941,940.00	5,369,190.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	335,848,800.00	389,060,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	335,848,800.00	389,060,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,763,700.00	285,700,292.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,828,200.00	238,997,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,828,200.00	233,992,450.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,005,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,935,500.00	46,702,842.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,935,500.00	46,702,842.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	462,938,097.69	970,845,875.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462,938,097.69	970,845,875.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	459,217,357.69	891,556,295.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,572,373.00	292,288,247.00
210101	Үндсэн цалин	165,151,233.00	172,038,161.00
210102	Нэмэгдэл	79,402,342.00	93,487,398.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,927,000.00
210104	Урамшуулал	17,018,798.00	21,835,688.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,745,654.00	37,964,897.00
210201	Тэтгэврийн даатгал	23,344,308.00	26,717,444.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,553,646.00	2,811,831.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,092,700.00	2,249,516.00
210204	Ажилгүйдлийн даатгал	523,200.00	562,304.00

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	5,231,800.00	5,623,802.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,616,255.00	41,887,842.00
210301	Гэрэл, цахилгаан	6,294,875.00	3,811,282.00
210302	Түлш, халаалт	16,846,500.00	36,989,600.00
210303	Цэвэр, бохир ус	474,880.00	1,086,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,069,180.00	26,030,336.00
210401	Бичиг хэрэг	1,713,980.00	3,121,200.00
210402	Тээвэр, шатахуун	10,835,400.00	15,846,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	563,100.00	2,085,266.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,400.00	3,050,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,134,300.00	1,927,000.00
2105	Нормативт зардал	59,993,532.12	415,348,641.54
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,212,442.12	401,431,966.54
210502	Хоол, хүнс	4,502,090.00	13,502,675.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,279,000.00	414,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,685,100.00	13,189,271.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,187,500.00	7,549,271.97
210604	Урсгал засвар	5,497,600.00	5,640,000.00
2107	Томилолт, зочны зардал	718,000.00	306,000.00
210702	Дотоод албан томилолт	718,000.00	306,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,775,238.00	4,998,394.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,343,238.00	4,620,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	170,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	111,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	70,000.00
210807	Газрын төлбөр	-	26,844.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,042,025.57	59,542,665.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,299,700.00	16,137,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,742,325.57	43,405,365.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,720,740.00	79,289,580.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,690,000.00	79,289,580.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	30,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,690,000.00	48,489,580.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,030,740.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,030,740.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,808,918.13	(10,001,932.96)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	727,000.00	1,281,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	727,000.00	1,281,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,203,971.66	7,776,400.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,203,971.66	7,776,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(12,476,971.66)	(6,495,400.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,331,946.47	(16,497,332.96)

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	405,554,440.00	680,129,682.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	360,790,740.00	394,429,390.00
122	Тусламжийн орлого	24,941,940.00	5,369,190.00
122001	Хандив тусламж /дотоод/	24,941,940.00	5,369,190.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	335,848,800.00	389,060,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	335,848,800.00	389,060,200.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,763,700.00	285,700,292.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,828,200.00	238,997,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,828,200.00	233,992,450.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,005,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,935,500.00	46,702,842.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,935,500.00	46,702,842.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	403,371,440.00	657,292,618.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,371,440.00	657,292,618.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,340,700.00	578,618,038.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,572,373.00	292,288,247.00
210101	Үндсэн цалин	165,151,233.00	172,038,161.00
210102	Нэмэгдэл	79,402,342.00	93,487,398.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,927,000.00
210104	Урамшуулал	17,018,798.00	21,835,688.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,745,654.00	37,964,897.00
210201	Тэтгэврийн даатгал	23,344,308.00	26,717,444.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,553,646.00	2,811,831.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,092,700.00	2,249,516.00
210204	Ажилгүйдлийн даатгал	523,200.00	562,304.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,231,800.00	5,623,802.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,663,755.00	41,872,842.00
210301	Гэрэл, цахилгаан	6,294,875.00	3,796,282.00
210302	Түлш, халаалт	14,894,000.00	36,989,600.00
210303	Цэвэр, бохир ус	474,880.00	1,086,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,262,500.00	24,949,916.00

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	1,743,300.00	2,501,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,835,400.00	17,072,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	563,100.00	1,256,166.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,400.00	2,820,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,298,300.00	1,300,000.00
2105	Нормативт зардал	33,792,680.00	155,919,242.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,769,990.00	146,015,367.00
210502	Хоол, хүнс	4,012,690.00	9,815,875.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,010,000.00	88,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,302,600.00	4,430,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,645,000.00	950,200.00
210604	Урсгал засвар	7,657,600.00	3,480,000.00
2107	Томилолт, зочны зардал	718,000.00	306,000.00
210702	Дотоод албан томилолт	718,000.00	306,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,775,238.00	4,998,394.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,343,238.00	4,620,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	170,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	111,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	70,000.00
210807	Газрын төлбөр	-	26,844.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,507,900.00	15,888,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,507,900.00	15,888,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,030,740.00	78,674,580.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	78,674,580.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	30,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	47,874,580.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,030,740.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,030,740.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,183,000.00</u>	<u>22,837,064.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,183,000.00	20,129,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,183,000.00	20,129,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,183,000.00	20,129,600.00
222001	Тоног төхөөрөмж	2,183,000.00	20,129,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,183,000.00)</u>	<u>(20,129,600.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,707,464.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,707,464.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,302,799.05	322,926,496.32	(198,703,138.92)		320,526,156.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,302,799.05	322,926,496.32	(198,703,138.92)	-	320,526,156.45
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C07	Тайлант үеийн үр дүн	-	-	21,331,946.47		21,331,946.47
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,302,799.05	322,926,496.32	(177,371,192.45)	-	341,858,102.92
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	196,302,799.05	322,926,496.32	(177,371,192.45)	-	341,858,102.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,302,799.05	322,926,496.32	(177,371,192.45)	-	341,858,102.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(16,497,332.96)		(16,497,332.96)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,302,799.05	322,926,496.32	(193,868,525.41)	-	325,360,769.96

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	483276000.00	453268626.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	483276000.00	446468926.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	482476000.00	430865368.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291557500.00	281054983.00
210101	Үндсэн цалин	184581400.00	172038161.00
210102	Нэмэгдэл	79282300.00	82254134.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5544000.00	4927000.00
210104	Урамшуулал	22149800.00	21835688.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39360200.00	36515961.00
210201	Тэтгэврийн даатгал	27697800.00	25268508.00
210202	Тэтгэмжийн даатгал	2915600.00	2811831.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2332500.00	2249516.00
210204	Ажилгүйдлийн даатгал	583100.00	562304.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5831200.00	5623802.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56656400.00	41872842.00
210301	Гэрэл, цахилгаан	6007000.00	3796282.00
210302	Түлш, халаалт	49559400.00	36989600.00
210303	Цэвэр, бохир ус	1090000.00	1086960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22716500.00	20735166.00
210401	Бичиг хэрэг	1350000.00	1200000.00
210402	Тээвэр, шатахуун	15757200.00	14158800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,256,166.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,822,500.00	2,820,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,300,000.00
2105	Нормативт зардал	43,450,000.00	35,478,222.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,500,000.00	30,204,347.00
210502	Хоол, хүнс	7,940,000.00	5,185,875.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,010,000.00	88,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00	4,430,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	950,200.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	3,480,000.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00	306,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	306,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,505,100.00	4,998,394.00

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,624,100.00	4,620,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,000.00	170,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	111,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	41,000.00	26,844.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,930,300.00	5,473,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,930,300.00	5,473,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	15,603,558.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	14,803,558.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		14,803,558.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,799,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,799,700.00
222001	Тоног төхөөрөмж	-	6,799,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	483,276,000.00	455,935,790.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	389,060,200.00	389,060,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	389,060,200.00	389,060,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,506,400.00	61,506,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	61,506,400.00	61,506,400.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	32,709,400.00	5,369,190.00
122001	Хандив тусламж /дотоод/	32,709,400.00	5,369,190.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,667,164.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,828,200.00	238,957,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,828,200.00	225,627,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,628,200.00	147,752,670.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	11,233,264.00
210102	Нэмэгдэл	-	11,233,264.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,448,936.00
210201	Тэтгэврийн даатгал	-	1,448,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	228,200.00	4,214,750.00
210401	Бичиг хэрэг	-	1,301,200.00
210402	Тээвэр, шатахуун	228,200.00	2,913,550.00
2105	Нормативт зардал	13,400,000.00	120,441,020.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,400,000.00	115,811,020.00
210502	Хоол, хүнс	-	4,630,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,414,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,414,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	77,874,580.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	77,874,580.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	30,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	47,074,580.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,329,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,329,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	13,329,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,828,200.00	238,997,450.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,828,200.00	238,997,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,828,200.00	233,992,450.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,005,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	40,300.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дашинчилэн сумын ЭМТ нь “Сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанар, аюулгүй байдлыг хангаж үйлчлэх” гэсэн зорилго тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дашинчилэн сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлогын 496.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2021 оны санхүүгийн тайлангийн нийт 680.1 орлогын сая төгрөгөөс 2 хувь буюу 13.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож ажиллалаа.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дашинчилэн сумын ЭМТ нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна. Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дашинчилэн сумын ЭМТ нь 2021 онд улсын төсвөөс 389.1, орон нутгийн төсвөөс 61.9, ЭМДС-гаас 32.7 сая төгрөг буюу нийт 483.7 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тус сумын ЭМТ нь 2021 он улсын төсвөөс 389.1, орон нутгийн төсвөөс 46.7, ЭМДСангаас 5.3, нэмэлт дансаар 234.0, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5.0 сая төгрөгийн буюу нийт 680.1 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 677.4 сая төгрөгийг зарцуулж мөнгөн гүйлгээний тайлангаар 2.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дашинчилэн сумын ЭМТ нь 2021 онд нэмэлт дансаар нийт 238.9 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 198.6 сая төгрөгийг зарцуулж 0.04 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дашинчилэн сумын ЭМТ нь урьдчилан сэргийлэх үзлэгээр 2.0, дархлаажуулалтын 1,2-р тунгийн 20.6, өрхийн ковидоор 12.9, хэвтэн эмчлүүлсэний 164.0 буюу нийт 199.3 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр цалингийн зардалд 11.2, НДШ-д 1.4, бичиг хэргийн зардалд 1.3, эм эмнэлгийн хэрэгсэлд 111.4, хоол хүнсний зардалд 4.6, үндсэн хөрөнгө, бараа материал худалдан авах зардалд 23.2, тэтгэмжинд 46.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тус сумын ЭМТ нь 2021 онд ковид буюу цар тахалтай холбогдуулаад ЭМС-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалуудыг үндэслэн мөнгөн тэтгэмж урамшуулалд 30.8, ковидын урамшуулал, нэмэгдэл цалинд 46.1 сая төгрөгийг тус тус олгожээ.

Хандив тусламжаар ЭМЯ-наас 8.5, ЭМГ-аас 4.8, иргэдээс 3.0, “Баян-гол мед” ХХК-иас 1.4 буюу нийт 17.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, эм боох болон хамгаалах хэрэгслийн 238.6, хоол хүнсний 3.0, туслах материал 17.9, аж ахуй материалын 3.1 сая төгрөгийн материалыг тус тус орлого авч тайлагнажээ.

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй 7.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулга хийх албан тоот хүсэлтийн дагуу санхүүгийн тайланд залруулга хийж баталгаажууллаа.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 12 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор ковидын урамшуулалыг давхардуулж, НДШ-ийг суутган тооцоогүй 17.9 сая төгрөгийг олгосон, батлагдсан орон тоог 1 орон тоогоор хэтрүүлсэн, бараа үйлчилгээний зардлаас шагналын зардлыг шилжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэлд дутуу цохолтын баримт бөглөгдөөгүй, хөтөч ажилтаны цалингийн зардлыг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд шилжүүлсэн зэрэг зөрчлүүд илэрч байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэх мэдээллийг бүрэн мэдээлж ажилласан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 1 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 22 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан ч өмнөх алдаа давтагдаж байгаа нь зөвлөмжийн биелэлтийг хангалтгүй биелүүлж өмнөх алдаа зөрчил давтагдсан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жилийн эцсийн байгууллагын хөрөнгийн тооллогыг чанаржуулж, хуулийн хүрээнд хагас бүтэн жилээр хөрөнгө, материалын тооллогын үлдэгдлийг баталгаажуулан ажиллаж хэвших шаардлага үүсэж мөн 2022 оноос эхлэн гүйцэтгэлээрээ санхүүжиж байгаатай холбогдуулан өөрийн үйл ажиллагааны орлого болон гүйцэтгэлийг дараагийн аудитаар шалгах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 18.7 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 0.7 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага, 6.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, 7.4 сая төгрөгийн 1 алдааг залруулж ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тодруулга тайлангийн 7.4 сая төгрөгийн материалын зарлагын дансыг буруу илэрхийлсэн зөрчлийг НББ-ийн тухай 15 дугаар зүйлд заасны дагуу залруулга хийж баталгаажуулан ажиллалаа.

4.2 Төлбөрийн акт

1.Тус сумын ЭМТ нь бараа үйлчилгээний зардлаас 226000 төгрөгийг шагнал урамшуулалын зардалд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “зардлын эдийн засгийн ангилах, ашиглах зааварыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны ковид цар тахалтай холбогдуулан олгосон тэтгэмж, урамшуулалыг түүвэрлэн шалгахад 17920950 төгрөгийг хүчингүй болсон хуулийн заалтыг үндэслэн, НДШ-ийг суутган тооцоогүй, тэтгэмж давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, ЭМС-ын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалын заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

3. Тус сумын ЭМТ-ийн 2021 оны шатахуун зарцуулалтыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахуун зарцуулалтын даргын цохолт бөглөгдөөгүй, хаашаа хэн явсан нь тодорхойгүй баримтаар 551611 төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Тус сумын ЭМТ нь 2020 оны санхүүгийн тайлан баталагаажуулах аудитаар даргын цохолтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй зөрчил илэрч төлбөрийн акт бичигдэж байсан боловч 2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар няравын тайлагнасан шатахуун зарцуулалтын тайлангаас түүвэрлэн шалгахад 736500 төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй зөрчил илэрч байгаа нь өмнөх алдаа зөрчлийг залруулж ажиллаагүй, дахин давтагдаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “”, Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1.1-д “хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн;” 37 дугаар 1.13-д “албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” тул гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага бичлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын орон тоотой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Батлагдсан орон тооноос 1 орон тоогоор илүү ажиллуулж 5.0 сая төгрөгийн цалинг нэг удаагийн тэтгэмж урамшуулалаас зарцуулсан.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан орон тоонд багтааж төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-нд “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”,

2. Нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Хөтөч ажилтаны 12 сарын 420.0 мянган төгрөгийн цалинг нэг удаагийн тэтгэмж урамшуулын зардлаас олгосон.

2.2 Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилалаар нь шилжүүлэн зарцуулж, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар”-ыг мөрдлөгөө болгож ажиллах.

3. Шатахууны зардалтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Бараа материалын тодруулга тайланд вакцин хүргэлтийн шатахууны 894.1 мянган төгрөгийн орлогыг тайлагнаагүй шууд зардлаар бүртгэсэн.

3.2 Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын 2019 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “НББ-ын дансны заавар”-ын Бараа материал хэсгийн 4.16 “бараа материалыг ангилж

бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө.” гэж заасны дагуу бүртгэлийг үнэн зөв бүртгэж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая/төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дашинчилэн сумын ЭМТ	8	33.2	1	7.4	3	18.7	1	0.7	3	6.4

